

ХАМТАРСАН БАГ



ХАЛАМЖИЙН НИЙГМИЙН АЖИЛТАНД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭСЭС
УРЬДЧИЛАН СЭРТГИЛЭХ АНЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВӨЛӨЛ



From
the People of Japan

Нэмж засварласан 3 дахь хэвлэлт

© Хүүхдийг ивээх сан (2016, 2019)

© Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк (2023)

Боловсруулсан:

Б.Сүх-Очир (2016, 2019)

Э.Дуламсүрэн (2023)

Хянан тохиолдуулсан:

Х.Өлзийтунгалаг

Г.Ойнбаяр

Э.Дуламсүрэн (2016, 2019)

Р.Нарантуяа ХНХЯ (2023)

Г.Амаржаргал ГХУСАЗЗАА (2023)

Гарын авлагын зургийг:

Г.Ганбаяр (2016, 2019, 2023)

Нэмж засварласан 3 дахь хэвлэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк хамтран "Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх" төслийн санхүүжилтээр хэвлэв.

Гарчиг

Агуулга	
Шигтгээ, зураг, хүснэгтийн жагсаалт	4
ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ БА ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ	5
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ХАЛАМЖИЙН НИЙГМИЙН АЖИЛТНЫ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА	7
1.1.Хамтарсан багийн гишүүн-Халамжийн нийгмийн ажилтны эрх, үүрэг	7
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХАЛАМЖИЙН НИЙГМИЙН АЖИЛТНЫ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ.....	12
2.1.Халамжийн нийгмийн ажилтнаас гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх хамгааллын үйлчилгээ.....	12
2.2 Халамжийн нийгмийн ажилтны үзүүлэх халамжийн үйлчилгээ	14
2.3 Хамтарсан багийн үйлчилгээний төсөв, санхүү	18
2.4 Үйлчлүүлэгчийн зүгээс гарч болох асуудал, бэрхшээл, ажиллах арга зүй	19
Ашигласан материал.....	22

ШИГТГЭЭ, ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хамтарсан багийн үйл ажиллагааны зарчим.....	7
Зураг 2. Хамгааллын үйлчилгээний түвшин	12
Зураг 3 Кейс менежментийн үе шат.....	13
Хүснэгт 1. Нийгмийн ажилтны эрх, үүрэг	8
Хүснэгт 2. Хамтарсан багт халамжийн нийгмийн ажилтан.....	9
Хүснэгт 3. Кейс менежментийн үе шат ба халамжийн нийгмийн ажилтны анхаарах зүйлс	13
Хүснэгт 4. Ажилд зуучлахад шаардлагатай халамжийн нийгмийн ажилтны нийтлэг ур чадвар.....	17
Хүснэгт 5. Хамгааллын үйлчилгээний төсөв.....	19
Хүснэгт 6. Үйлчлүүлэгчтэй харилцах, ярилцах, сонсох арга.....	20
Хүснэгт 7. Халамжийн нийгмийн ажилтны зөвлөгөө өгөх ур чадвар	21

ЖЕНДЕРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

“ЖЕНДЕРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ” гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл эс эс үйлдэхүйг хэлнэ.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиас

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Гэр бүлийн хамаарал бүхий хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод хандсан үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Гэр бүлийн хамаарал бүхий хүнийг өөрийн эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг хэлнэ.

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ

Биеийг нь үнэлүүлэх бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах. Эд эрхтнийг авах албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлах, хууран мэхлэх итгэл эвдэж. Эрх мэдлээ урвуулан ашиглаж эмзэг байдлыг нь дамжуулж эсхүл бол хяналтдаа байлгаж байгаа хүн төлбөр төлж, хахуульдаж, хүнийг эрхшээлдээ оруулан Элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан үйлдлийг хэлнэ.

АЖЛЫН БАЙРНЫ БЭЛГИЙН ДАРАМТ

Бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн. Эс л бол харьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан. Мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй Орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл эс үйлдэхүйг эсхүл бэлгийн сэдэлтэй аливаа үйлдлийг давуу эрх Болгож эдлүүлэх болзол болгон тавихыг хэлнэ.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

1. БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЭЛ

гэр бүлийн хамаарал бүхий хүний амь нас эрүүл мэндэд гэм хор учруулсан эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдлээс үйлдэхүй хэлнэ.

2. БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Гэр бүлийн хамаарал бүхий хүний эрхшээлтэй байгаа байдлыг далимдуулан энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг хэлнэ.

3. СЭТГЭЛ САНААНЫ ХҮЧИРХИЙЛЭЛ

Гэр бүлийн хамаарал бүхий хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх эсхүл хийхгүй байхыг албадан албадах. Үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгөх, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг

4. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Гэр бүлийн хамаарал бүхий хүний цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээрийн адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө. Эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах оролд. Орлого олох боломжийг нь хязгаарлах шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах. Тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан эсхүл бол эд хөрөнгийн хохирол учруулсныг хэлнэ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ХАЛАМЖИЙН НИЙГМИЙН АЖИЛТНЫ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. ХАМТАРСАН БАГИЙН ГИШҮҮН-ХАЛАМЖИЙН НИЙГМИЙН АЖИЛТНЫ ЭРХ, ҮҮРЭГ

Хамтарсан багийн үзэл баримтлал нь гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэлд төрийн нэрийн өмнөөс хөндлөнгөөс оролцож, гэр бүлийн гишүүн тус бүрийн хэрэгцээг өөрсдийн мэргэжил, үүрэг хариуцлагын үүднээс үнэн зөв тодорхойлж, хамтдаа системчилсэн үнэлгээ хийж, хүрээлэн буй нийгмийн орчны нөлөө, гэр бүл болон хувь хүний онцлог, давуу талд тулгуурлан, тэдний оролцоотойгоор асуудлыг цогцоор шийдвэрлэх явдал юм.

Зураг 1. Хамтарсан багийн үйл ажиллагааны зарчим



Хамтарсан багт салбар бүрийн мэргэжилтнүүд албан тушаал, мэргэжлийн үүргийн дагуу орж байгаа нь хамтдаа гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт шатанд нь илрүүлэх, шуурхай таслан зогсоох, нэгэнт өртсөн хүмүүст эрүүл мэнд, сэтгэл санааны хувьд хэвийн нөхцөл байдалд эргэн ороход нь дэмжлэг үзүүлэх, цогц үйлчилгээ үзүүлэх зорилготой.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу халамжийн нийгмийн ажилтан нь эрсдэлт нөхцөл байгаа хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид халамжийн үйлчилгээг хүргэх, хүүхэд, гэр бүлийг хүчирхийлэл дарамтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, эрт шатанд илрүүлэн эрүүл мэнд, сэтгэл зүй, хууль зүй, нийгмийн халамж, хамгааллын нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлнэ.

Нийгмийн ажилтан гэдэг нь баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажлын үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтныг хэлнэ. Нийгмийн ажилтан нь хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийтэд тулгарч буй асуудалд чиглэн үйлчлүүлэгчтэй тулж ажиллах,

үйлчлүүлэгчийн амьдарч буй орчны тогтолцоонд нийгмийн үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулах зэргээр нийгмийн бодлогын төлөвлөлт, зохицуулалтад нөлөөлөх, судалгаа үнэлгээ хийх чиглэлээр ажиллана¹.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн дагуу халамжийн нийгмийн ажилтан дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээж байна. Үүнд

Хүснэгт 1. Нийгмийн ажилтны эрх, үүрэг

Нийгмийн ажилтны эрх	Нийгмийн ажилтны үүрэг
- Нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх байгууллага, иргэнийг сонгоход оролцох, үйлчилгээнийх нь чанарт хяналт тавих, үнэлгээ хийх; - Шаардлагатай мэдээ, судалгаа болон холбогдох баримт бичгийг тухайн байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах; - Халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн бусад баримттай холбогдсон тайлбар, лавлагаа гаргуулж авах; - Мэргэжлийн ёс зүй, эрх, үүрэгт нь болон үйлчлүүлэгчид харш үйлдэл гүйцэтгэхээс татгалзах; - Нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд орон нутгийн байгууллага, иргэнийг татан оролцуулах; - Ажлын онцлогоос шалтгаалан тусгай өрөө, эсхүл тусгаарлалт бүхий ажлын байр болон шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангагдах эрхтэй.	- Тухайн сум, хорооны нийгмийн халамжид хамрагдах эрх, иргэний тоо болон хэрэгцээний судалгаа гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх; - Нийгмийн халамжид хамрагдах эрх, иргэний нөхцөл байдлыг үнэлж, хөгжлийн төлөвлөгөөг тухайн эрх, иргэнтэй хамтран хийж, хэрэгжүүлэх; - Тэтгэвэр, тэтгэмж авах, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээнд хамрагдах эрх, иргэнийг тодорхойлж, шийдвэрлүүлэх; - Өрх, иргэдийг хүсэл, зорилго, хэрэгцээгээрээ бүлэг болгон зохион байгуулагдахад нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; - Өрх, иргэдийг амьжиргаагаа дээшлүүлэх чадавхтай болоход нь туслах зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах; - Орон нутгийн иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагыг мэдээллээр хангах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хамтран ажиллах; - Нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг чандлан сахих; - Нийгмийн ажилтанд хандсан хувь хүний /хууль зөрчсөн үйлдлийг мэдээлэхээс бусад тохиолдолд/ нууцыг чандлан хадгалах; - Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж, журам, зааврыг хэрэгжүүлэх; - Хүн ам, гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр батлагдсан үндэсний хөтөлбөр, арга хэмжээг орон нутагтаа хэрэгжүүлэх ажлыг эрүүл мэндийн, боловсролын болон бусад нийгмийн ажилтантай хамтран зохион байгуулах; - Иргэнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний талаар бүрэн мэдээлэл өгөх; - Өрх, иргэнийг нийгмийн халамжийн үйлчилгээнд үр дүнтэй хамруулах зорилгоор эрүүл мэнд, боловсролыг дэмжих зэрэг нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагатай зуучилж өгөх үүрэгтэй.

Хүүхдийн эсрэг болоод гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлж тэднийг нийгэм, эдийн засгийн хувьд бусадтай тэгш оролцох боломжийг халамжийн нийгмийн ажилтан олгоно.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 40 дүгээр зүйлд Нийгмийн халамжийн үйлчилгээг “хохирогчид үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1-д заасан төрөлтэй байна” гэж заасан. Нийгмийн халамжийн үйлчилгээ нь халамжийн тусламж дэмжлэг шаардлагатай бүлгүүдэд чиглэдэг онцлогтой бөгөөд халамжийн нийгмийн ажилтан нь хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгч тус бүрийн бие даасан байдал, хувийн онцлог, соёлын өвөрмөц байдал, ялгаатай байдалд хүний эрхийн мэдрэмжтэй хандах шаардлагатай.

¹ Нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, MNS 694952021

Хүний эрхийн гол зарчим бол хүний бие, сэтгэл, соёлын болон нийгмийн ялгаанаас үл хамааран бүх хүнд адил тэгш нөхцөл, боломж бий болгоход орших төдийгүй бүх төрлийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх ёстой бөгөөд үүнийг Монгол Улс Үндсэн хуулиар тунхагласан.

Гэр бүлийн болоод хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчирхийллийн шалтгаан, хүчин зүйлийг бууруулахад гэр бүлийн гишүүдийг ажил орлоготой болгох, мэргэжилтэй болгох, шаардлагатай дэмжлэг, үйлчилгээнд холбож өгөхөд халамжийн нийгмийн ажилтан нь хамтарсан багт голлох үүрэгтэй оролцоно.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нь хүчирхийллийн суурь ба дам хүчин зүйлсэд өртөж, хүчирхийлэл үйлдэгчээс хараат болсон байдаг. Тиймээс хохирогчийг гэр бүлийн хүчирхийллээс ангид байхад нь туслах, сэтгэл зүйн хямрал, асуудлаа даван туулах, өөрийн амьдралд нөлөөлөх шийдвэр гаргахад нь туслах, эрх мэдэлжүүлэх, ажилтай болгоход нь туслах зэрэг цогц үйлчилгээ үзүүлэх шаардлагатай.

Нөгөө талд хүчирхийлэл үйлдэгчид хүчирхийлэх зан үйлээ өөрчлөх, хүчирхийллийн бус аргаар асуудлыг шийдэх, уур бухимдлаа зохицуулахад туслах үйлчилгээ, интервенц үзүүлэх, хэрэв архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ биеэ барих чадваргүй болдог бол архины эмчилгээнд, АА бүлэгт оруулж, шаардлагатай үйлчилгээг үзүүлнэ. Ажил хөдөлмөр эрхэлдэггүй, мэргэжлийн боловсролгүй байдлаас болж тогтвортой ажил, орлоготой болж чадаагүй бол аймаг, дүүргийн Насан туршийн боловсролын төв болон МСҮТ, бусад ижил төстэй сургалтын байгууллагад холбон зуучилснаар асуудлыг шийдвэрлэхэд тусална.

Эдгээрийг хамтарсан багийн хуулиар хүлээсэн чиг үүргийг халамжийн нийгмийн ажилтны хийж болох үйл ажиллагаатай уялдуулбал дараах үйл ажиллагааг хийхийг зөвлөж байна.

Хүснэгт 2. Хамтарсан багт халамжийн нийгмийн ажилтан

№	Хамтарсан багийн хуулиар хүлээсэн чиг үүрэг	Халамжийн нийгмийн ажилтан ЮУ ХИЙХ вэ?
	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах	- Хамтран ажиллаж болох төрийн болон төрийн бус байгууллагатай холбоо тогтоож, ажиллах; - Орон нутгийн иргэдээс эрэлт хэрэгцээний талаар судалгаа хийх; - Нийгмийн халамжийн үйлчилгээ авч буй иргэдэд төрөлжүүлсэн зөвлөгөө, сургалтыг зохион байгуулах; - Тэтгэвэрт гарсан туршлагатай ахмад настны нөөц, боломжийг дайчлан ажиллах; - Үндэсний түвшинд хийгдсэн судалгаа, шинжилгээний үр дүнтэй танилцаж, орон нутгийн түвшинд хэрэгжүүлж болох үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхийг зөвлөж байна.
	Хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;	- Нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлэх явцад хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх; - Халамжийн үйлчилгээ үзүүлж байгаа иргэдэд хамтарсан багийн талаар мэдээллийг өгч, асуудал гарвал хаана, хэнд, хэрхэн хандахыг зөвлөх үйлчилгээг халамжийн нийгмийн ажилтан хэрэгжүүлж болно.
	Нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчид үзүүлэх үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх	- Хамтарсан багаар ажиллах журмын дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийхэд хамтран оролцох; - Халамжийн үйлчилгээ шаардлагатай эсэхийг тодруулах; - Үйлчлүүлэгчийн ажил, мэргэжилтэй болоход холбон зуучлах үйлчилгээг үзүүлэхийг зөвлөж байна.
	Хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах	- Үйлчлүүлэгчийг халамжийн үйлчилгээнд хамруулах; - Нийгмийн халамжийн бусад үйлчилгээнд холбон зуучлах; - Холбон зуучлах боломжтой байгууллагын мэдээллийн санг бүрдүүлэх; - Хамтарсан багийн хуралдаанд оролцоно.

	Хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалт, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх замаар нөхөн сэргээж, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх	• Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулж, холбон зуучлах; • Жижиг дунд бизнес эрхлэх боломжийг олгосон сургалт, хөтөлбөр үйл ажиллагааг зохион байгуулах; • Чиг үүргийн хүрээнд хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх; • Орон нутгийн хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран үйл ажиллагааг зохион байгуулах үйл ажиллагааг халамжийн нийгмийн ажилтан хэрэгжүүлнэ.
	Хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаарх статистик мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх	• Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу үйлчилгээ үзүүлсэн, авсан иргэдийн тоо мэдээллийг тайлагнах; • Үйлчилгээ авч чадахгүй байгаа иргэд, хохирогчдын талаарх судалгаа хийх; • Хамтарсан багийн төлөвлөгөө, тайланд Халамжийн үйлчилгээ, үйл ажиллагааны тоо, мэдээллийг оруулж, холбогдох газруудад хүргүүлэх үйл ажиллагааг хийнэ.

Жич: Эдгээр санал болгож буй үйлчилгээг хамтарсан багийн гишүүн халамжийн нийгмийн ажилтан өөрийн боломж, орон нутгийн нөөц боломжид тулгуурлан хийж, хамтарсан багт өөрийн хувь нэмрийг оруулна.


ХАЛАМЖИЙН НИЙГМИЙН АЖИЛТНЫ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

2.1. ХАЛАМЖИЙН НИЙГМИЙН АЖИЛТНААС ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хувь хүн, гэр бүл, бүлэг, байгууллага, олон нийтэд чиглэсэн нийгмийн ажлын шууд ба шууд бус үйлчилгээ эрхэлдэг төр, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, нийгмийн ажилтан дагаж мөрдөнө.

Нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагын дагуу хамгааллын үйлчилгээг 1) Хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээ, 2) хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, 3) урьдчилан сэргийлэх үйлчилгээ гэсэн гурван түвшинд үзүүлнэ.

Зураг 2. Хамгааллын үйлчилгээний түвшин



Санамж: Энэ үйлчилгээний хүрээнд халамжийн нийгмийн ажилтан өөрийн үйл ажиллагааг уялдуулан ажиллахыг зөвлөж байна/


Энэхүү хамгааллын цогц үйлчилгээг төрийн анхан шатны нэгж болох сум, баг, хорооны хамтарсан багийн гишүүн тус бүр нь өөрийн ажил мэргэжлийн чиглэлээр хүчирхийлэл, дарамтад өртсөн хохирогчдод, хүүхдэд холбогдох хууль, эрх зүй, дүрэм журмын дагуу үзүүлнэ.

Нийгмийн ажлын үйлчилгээг шууд ба шууд бус гэж хоёр ангилна. Шууд үйлчилгээг үйлчлүүлэгчтэй тулж ажиллах замаар хүргэдэг бол, шууд бус үйлчилгээг судалгаа хийх, нөлөөллийн ажил зохион байгуулах, бодлого боловсруулах зэрэг хэлбэрээр хийнэ. Зорилтот болон эрсдэлт нөхцөлд байгаа үйлчлүүлэгчдэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхдээ кейс менежментийн арга зүйг хэрэглэнэ.

Зорилтот болон эрсдэлт нөхцөл байгаа үйлчлүүлэгчийн хэрэгцээнд чиглэсэн халамж хамгааллын үйлчилгээ үзүүлэх, бусад үйлчилгээтэй холбон зуучлах замаар тодорхой цаг хугацаанд нь тохиромжтой хэлбэрээр, системтэй шийдвэрлэх мэргэжлийн үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх арга замыг кейс менежмент гэнэ².

Халамжийн нийгмийн ажилтан нь хамтарсан багийн бусад гишүүдтэй хамтран хүчирхийллийн хэргүүд дээр ажиллахдаа кейс менежментийн хэрэгжилтийн үе шатыг баримтлан ажиллана. Үүнд: 1) харилцаа холбоо тогтоох, илрүүлэх, 2) нөхцөл байдлын үнэлгээ хийх, 3) үйлчилгээг төлөвлөх, 4) үйлчилгээг хэрэгжүүлэх, 5) үйлчилгээг үнэлэх, 6) үйлчилгээг хаах гэсэн үе шаттай байна.

Зураг 3. Кейс менежментийн үе шат



Хүчирхийллийн хохирогч нь хүүхэд, эмэгтэй, эрэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан байхаас үл хамааран, хамгааллын үйлчилгээг үзүүлэхдээ кейс менежментийн үе шатыг дагаж ажиллахыг зөвлөж байна. Кейс менежментийн үе шат бүрд холбогдох журмын дагуу маягтыг бөглөж, баримтжуулна. Халамжийн нийгмийн ажилтан дараах зүйлийг анхаарч ажиллана.

² Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага, MNS 6949:2021

Хүснэгт 3. Кейс менежментийн үе шат ба халамжийн нийгмийн ажилтны анхаарах зүйлс

Кейс менежментийн үе шат	Хамтарсан багаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Халамжийн мэргэжилтэн нийгмийн ажилтны анхаарч ажиллах зүйлс
Алхам 1. Харилцаа холбоо тогтоох, илрүүлэх	Хохирогч хүчирхийлэл, дарамтад өртсөн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд кейс нээж, үйлчилгээг үзүүлж эхлэх	- Хүчирхийллийг илрүүлэх; - Хүчирхийллийн мэдээллийг хамтарсан багийн гишүүдэд мэдэгдэнэ.
Алхам 2. Нөхцөл байдлын үнэлгээ хийх	Хамтарсан багаар ажиллах журмын дагуу Хамтарсан багийн хоёроос доошгүй хүн нөхцөл байдлын үнэлгээг журмын дагуу ³ 72 цагийн дотор хийнэ.	- Нөхцөл байдлын үнэлгээ хийхэд оролцох; - Кейс файл бүрдүүлэх; - Үйлчлүүлэгчдэд шаардлагатай нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлнэ⁴.
Алхам 3. Үйлчилгээний төлөвлөгөө боловсруулах	Үйлчилгээний төлөвлөгөөг үйлчлүүлэгчийн оролцоонд тулгуурлан, хамтарсан багийн гишүүд боловсруулна.	- Үйлчлүүлэгчийг төлөвлөгөөнд оролцуулах; - Нийгмийн халамжийн үйлчилгээг төлөвлөх; - Мэргэжлийн нийгмийн ажилтан кейс менежер хийх; - Холбон зуучлах үйлчилгээг үзүүлнэ.
Алхам 4. Үйлчилгээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Хамтарсан багийн гишүүд болон үйлчилгээ авагч нь төлөвлөгөөний дагуу хуваарь, хариуцахаар тогтсон үүрэгт ажлуудаа бүрэн гүйцэтгэнэ.	- Халамжийн нийгмийн ажилтан нь төлөвлөгөөнд орсон ажлаа хариуцан гүйцэтгэх; - Хамтарсан багийн бусад гишүүдэд мэргэжил, арга зүйн хувьд дэмжлэг үзүүлнэ.
Алхам 5. Үйлчилгээг үнэлэх	Хамтарсан багийн гишүүд үйлчилгээг үйлчлүүлэгч, түүний гэр бүлийн гишүүдтэй хамтран үнэлнэ.	- Багийн бусад гишүүдтэй хамтран үнэлгээг хийх; - Кейс дээр үзүүлсэн үйлчилгээг үнэлэхэд нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлсэн талаар багийн бусад гишүүдэд мэдээлэх, тайлагнана.
Алхам 6. Үйлчилгээг хаах	Үйлчлүүлэгч эргэж хэвийн амьдралдаа орсон бол хамтарсан багийн гишүүдийн хамт баримтжуулан, тодорхой шаардлагыг ханган, үйлчилгээг хаана.	- Үйлчилгээ үзүүлсэн тухай баримтыг бүрдүүлэхэд оролцох; - Үйлчилгээг хаагдсанаас хойш үйлчлүүлэгчийг хэрхэн амьдарч байгаад ажиглалт хийнэ.

Санамж: Кейс менежмент нь цогц үйл ажиллагаа бөгөөд хамтарсан багийн гишүүний хувьд халамжийн нийгмийн ажилтан өөрийн чиг үүргийн хүрээнд хариуцан хэрэгжүүлнэ.

2.2 ХАЛАМЖИЙН НИЙГМИЙН АЖИЛТНЫ ҮЗҮҮЛЭХ ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 40 дүгээр зүйлд Нийгмийн халамжийн үйлчилгээг “хохирогчид үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1-д заасан төрөлтэй байна” гэж заасан.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд дараах үйлчилгээ орно. Үүнд:

- Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах;

³ Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага, MNS 6949:2021

⁴ Холбон зуучлах үйлчилгээний журам, маягтыг хэрэглэнэ.

- Зөвлөгөө өгөх;
- Сэргээн засах үйлчилгээнд хамруулах;
- Түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах;
- Өдрийн үйлчилгээнд хамруулах;
- Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах;
- Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;
- Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;
- Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах;

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах гэсэн олон төрөлтэй байна.

Амьжиргааг дэмжих зөвлөл

Нийгмийн ажлын үйлчилгээ авч буй гэр бүл, хохирогчийг дэмжих зорилгоор нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулах эсэх талаар болон халамжийн үйл ажиллагаатай холбоотой гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үүргийг амьжиргааг дэмжих зөвлөл⁵ хүлээдэг. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сум, хорооны Засаг даргын санал болгосноор сум, хороонд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, иргэдийн Нийтийн Хурлаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байхаар хэлэлцэж батална. Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр нь хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд зааснаас бусад тохиолдолд нийтэд нээлттэй, ил тод байдаг. Амьжиргаа дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлэх үйлчлүүлэгч, түүний орчны нөхцөл байдлыг үнэлэх, үзүүлж болох үйлчилгээ, тусламжийн хэлбэрийг үйлчлүүлэгчтэй хамтран сонгох, тэрхүү сонголтыг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, бэлтгэл ажлыг халамжийн нийгмийн ажилтан хийнэ. Ийм л учраас хамтарсан баг, амьжиргааг дэмжих зөвлөлийн үйл ажиллагааг уялдуулах боломж нөөц нь халамжийн нийгмийн ажилтанд байна. Манай улсын хувьд сум, баг, хорооны түвшинд амьжиргааг дэмжих зөвлөлийн үйл ажиллагаа хэрэгжиж хэвшсэн бөгөөд эдгээр үйл ажиллагааг хамтарсан багаас хамгааллын үйлчилгээ авч буй хохирогчдод чиглүүлэх нь төрийн үйлчилгээний уялдаа холбоог сайжруулахад чухал үр нөлөөтэй.

Холбон зуучлах үйлчилгээ

Хамтарсан багаас шаардлагатай мэргэжлийн үйлчилгээг мэргэшсэн байгууллага/мэргэжилтнээс авч, үйлчлүүлэгчдэд хүргэдэг. Хамтарсан багийн гишүүдэд хамгааллын бүх үйлчилгээг үзүүлэхэд хүн хүч, нарийн мэргэжлийн ур чадвар дутмаг байх тохиолдол гардаг. Энэ тохиолдолд үйлчлүүлэгчдэд шаардлагатай үйлчилгээг холбон зуучлалаар дамжуулан хүргэнэ.

Холбон зуучлах үйлчилгээнд:

- Хууль, эрх зүйн үйлчилгээ
- Сэтгэл зүйн үйлчилгээ
- Насан туршийн боловсролын төвийн сургалтуудад хамруулах
- Ажлын байранд холбон зуучлах
- Мэргэжлийн боловсрол олгох байгууллагад холбох

⁵ Нийгмийн халамжийн тухай хуулийн 7 дугаар зүйл, Амьжиргааг дэмжих зөвлөл

- Эрүүл мэндийн үйлчилгээ
- Дэмжих бүлэгт үйлчлүүлэгчийг хамруулах
- Эрүүл зан үйлд сургах сургалт, бүлэгт оруулах
- Аж төрөх ухааны сургалт, хөтөлбөрт хамруулах гэх мэт үйлчилгээ орж болно.

Холбон зуучлах үйлчилгээг үзүүлэхдээ мэдээллийн санг бүрдүүлэх нь чухал. Мэдээллийн санд орон нутагт дахь төрийн болон төрийн бус, хувийн хэвшил гэх мэт байгууллагууд, тэдгээрийн зорилго, үйл ажиллагааны чиглэл, хаяг зэргийг оруулж болно.

Холбон зуучлах үйлчилгээг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/73 дугаар тушаалаар батлагдсан "Холбон зуучлах үйлчилгээний журам"-ын дагуу Холбон зуучлах үйлчилгээний илгээх хуудас, Холбон зуучлах үйлчилгээний хамтарсан төлөвлөгөө, Холбон зуучлах үйлчилгээний эргэн мэдээлэх маягтыг хөтөлнө.

Үйлчлүүлэгчийг ажилд холбон зуучлах

Хохирогчийг эдийн засгийн хувьд эрх мэдэлжүүлэх нь халамжийн нийгмийн ажилтны ажлын чиг үүрэгт хамаардаг.

Ажилд зуучлал бол хөдөлмөр эрхлэлтийн сонгодог, суурь, үндсэн үйлчилгээ юм. Ажилд, мэргэжлийн боловсролд зуучлах гэдэг нь үйлчлүүлэгчийг хөдөлмөрийн зах зээлтэй холбож, мэргэжлийн үйлчилгээнд хамруулж, түүнд энэ чиглэлийн дэмжлэг үзүүлж буй хэрэг юм⁶.

Холбон зуучлах үйлчилгээний явцад ажил хайгчийн болон ажил олгогчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэх шаардлагын улмаас зуучлагчийн хувьд буюу халамжийн нийгмийн ажилтан нь холбон зуучлах гэж байгаа ажлын байрны талаар бүрэн мэдээлэлтэй, ажлын нөхцөл, ажил олгогчоос тавьж буй шаардлага, үүсэж болох бэрхшээл зэргийг үнэлж цэгнэсэн байвал зүйтэй.

Халамжийн нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгчдэд хөдөлмөр эрхлэхэд чиглэсэн зөвлөгөө өгдөг. Ажил хайгчийн шинж чанар, эрэлт болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шинж чанарын хоорондын нийцлийг тайлбарлах шаардлага гарна. Ажил мэргэжлийг хоёр том үзүүлэлтээр ангилж болно. Нэгдүгээрт, тухайн ажил мэргэжлээр ажиллахад шаардагдах мэдлэг, мэргэжлийн бэлтгэлийн түвшин, хоёрдугаарт, тухайн ажил мэргэжлээр ажиллах үед юутай харьцаж, ямар орчинд ажиллах вэ гэдгээр үзэж болно.

Нийгмийн халамжийн салбарт бодлогын шинэчлэл хийгдэж "халамжаас хөдөлмөрт" бодлогын шинэчлэлийн дагуу нийгмийн халамжийн зорилтот бүлгийн өрхтэй ажиллах, зорилтот бүлгийн хүмүүсийн зан үйл, хандлагыг өөрчлөх, тэднийг ядуурлаас гаргах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд анхаарч байна.

Хүснэгт 4. Ажилд зуучлахад шаардлагатай халамжийн нийгмийн ажилтны нийтлэг ур чадвар

№	Чадавх, хандлага, ур чадвар	Мэдлэг
	Техникийн чадвар	Ажилтан шалгаруулж авах, элсүүлэх хэлбэрүүд
	Үйлчлүүлэгчид төвлөрсөн	Хөдөлмөр болон нийгмийн хамгааллын хуулиуд
	Санаачилга	Хөдөлмөрийн зах зээлийн хандлага ба шинж чанар
	Үр дүнг баримжаалсан	Ажил олгогчдын зүгээс хамгийн их чухалчилж буй ажлын байрны шаардлагууд
	Төлөвлөлт ба менежмент	Ажил эрхлэлтийг дэмжих төрийн болон хувийн хөтөлбөрүүд
	Байгууллага доторх удирдлагын харилцаа	Суурь цалингийн аргачлал

⁶ Г.Түмэннаст, Ажилд зуучлах магистрын хөтөлбөрийн стратеги ба хөдөлмөр эрхлэлтэд чиглэсэн кейс менежмент, Зайн сургалтын гарын авлага, УБ.,2008

Ажил горилогч болон ажил олгогчид зөвлөгөө өгөх чадавх	Ажил эрхэлж буй хүмүүсийн чадвар болон шинж чанарыг сайн ойлгох (нийгэм, боловсрол, эдийн засаг, соёл)
Ойлгомжтой бөгөөд татах харилцааны чадвар	Чадавх хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийн агуулга
Шинжлэх ба тайлбарлах	Ажилд орох ярилцлагын арга техник
Бие хүн хоорондын харилцааны чадвар	Мэдээллийн сангийн менежмент ба хэрэглээ
Үр ашигтай уулзалт-дэмжлэг үзүүлэх чадвар	Бизнесийн салбарт ажилтан шалгаруулж авах үйл явц

Ажилд холбон зуучлах нь ажил горилогч болон ажил олгогч талуудын хамтын ажиллагааны үр дүнд амжилттай болдог. Холбон зуучлахдаа халамжийн нийгмийн ажилтан дараах чиглэлээр мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ⁷ хийж болно. Үүнд:

- Байгууллагын тухай мэдээлэл. Байгууллага, түүний хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал, ажлын байранд тавигдаж буй шаардлагуудын талаар мэдээлэл цуглуулна.
- Ажлын байрны талаарх мэдээлэл. Ажлын байр дээр ажиллаж буй ажиллагчдын нийцэл, цалин хөлс, гэрээний нөхцөлийн талаар мэдээлэл цуглуулна.
- Ажлын байрны шаардлага. Боловсрол, мэргэшил, туршлага, мэдлэг, чадвар, чадавх болон зан чанар, сэдэл, шилжилт хөдөлгөөний боломж, уян хатан байдал зэрэг үүнд хамаарна.
- Байгууллагын ажилтанд чиглэсэн үйлчилгээ. Ажил хайгч ажилтай болсон тохиолдолд ажил олгогчийн зүгээс үзүүлэх цалин урамшуулал, нэмэлт хангамж, тушаал дэвших болон хөгжих боломжууд, ажлын хамт олны уур амьсгал, бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэчлэл, хөдөлмөрийн хэрэгсэл, ажлын горим болон бусад нөхцөл зэрэг үүнд хамаарна.

Орчин үеийн хөдөлмөрийн зах зээл нь маш хурдтай хувьсан өөрчлөгдөж байна. Глобалчлал, мэдээлэл технологийн эрин үе орчин үеийн ажил мэргэжлийн шинж чанарыг өөрчлөхийн зэрэгцээ ирээдүйд ч ажил мэргэжил ямар байдалд шилжих талаар эргэцүүлэхэд хүргэж байна. Мэдээллийн технологи, олон талт мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар ажил горилогчийг хүссэн ажлын байранд нь зуучлах асуудал бодит хэрэгцээ болсон гэдгийг Ковид 19-ийн цар тахлын хорио цээрийн үед бид үүнийг илүү ойлгож, мэдэрч, хэрэглэсэн билээ.

Үйлчлүүлэгчийг тохирох байгууллагатай холбон зуучилснаар ажил дуусахгүй. Тодруулбал үйлчлүүлэгч болон илгээсэн байгууллагын ажилтны аль алинтай холбоо тогтоож, дараах чиглэлээр мэдээлэл авна. Үүнд:

- Үйлчлүүлэгч тухайн байгууллагад очсон эсэх
- Үйлчлүүлэгчид хүссэн үйлчилгээг нь үзүүлсэн эсэх
- Үйлчлүүлэгч хүлээн авсан үйлчилгээндээ сэтгэл ханамжтай байгаа эсэх
- Үйлчилгээний үр дүнд ямар нэгэн зүйл өөрчлөгдсөн эсэх Цаашид хэрхэх эсэхийг үнэлж ажиллана.

Ажилд холбосон үр дүнгийн талаарх мэдээллийг үйлчлүүлэгч болон холбон зуучилсан байгууллагын ажилтнаас авч, холбон зуучлах ажлын үр дүнг үнэлнэ. Холбон зуучлах үйлчилгээний маягтуудыг шаардлагын дагуу бүрдүүлснээр үйлчилгээгээ баримтжуулж, тайлагнах боломжтой болно.

⁷ Г.Түмэннаст, Ажилд зуучлах магистрын хөтөлбөрийн стратеги ба хөдөлмөр эрхлэлтэд чиглэсэн кейс менежмент, Зайн сургалтын гарын авлага, УБ, 2018

Холбон зуучлах нь нэг талаас байгууллагуудтай хамтран ажиллаж буй хэлбэр мөн боловч нөгөө талаас байгууллагуудын тусламжтайгаар үйлчлүүлэгчид шаардлагатай үйлчилгээ үзүүлж байгаа хэрэг юм. Нөгөө талаар тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилгод ч гэсэн нийцдэг. Тухайлбал, хүчирхийлэлд өртсөн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг мэргэжилтэй болох, ажилд холбон зуучлах хэрэгцээ байгаа бол аймаг, дүүргийн Насан туршийн боловсролын төвд ч гэсэн яг ийм үйл ажиллагааны зорилго, төлөвлөгөө байдаг. Хамгийн гол нь зөв байгууллагаа олж тогтоох, хамтран ажиллах хэрэгтэй.

Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэхэд үйлчлүүлэгчтэйгээ сайтар ярилцаж, үндсэн хэрэгцээг нарийн тодорхойлно. Нөхцөл байдлын үнэлгээ хийх явцад ямар дэмжлэг, үйлчилгээ хэрэгтэй, холбон зуучлах шаардлагатай нь гардаг ч харилцах, ярилцах, сонсох ур чадвар шаардлагатай.

2.3 ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСӨВ, САНХҮҮ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болоод Хүүхэд хамгааллын тухай хуулиар хамтарсан багт хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн кейс дээр ажиллахад шаардлагатай төсөв, хөрөнгөтэй байхыг заасан. Халамжийн нийгмийн ажилтан нь хамтарсан багт байснаар төсвийн уялдаа холбоог сайжруулах, үйлчлүүлэгчдэд үзүүлж буй нийгмийн хамгаалал болон халамжийн бодлогын уялдаа холбоог хангаж, зохицуулж чадна.

Хүснэгт 5. Хамгааллын үйлчилгээний төсөв

Холбогдох хууль, журам	Зүйл, заалт
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2019 он	46.3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн батлагдсан төсөв дээр нь нэмж олгох замаар төвлөрүүлж, сум, дүүргийн салбар зөвлөл, гэмт хэргийн нөхцөл байдал, цаашдын төлөвийг харгалзан хуваарилж, зарцуулна.
Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016 он	23 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын санхүүжилт 23.1.хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ. 23.2.иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг дарга хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажил, үйлчилгээний зардал, нийгмийн ажилтны урамшууллыг улс болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.
Нийгмийн халамжийн тухай хууль, 2012 он	18.3.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд шаардагдах хөрөнгийг сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тооцож нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Нийгмийн халамжийн тухай хуулиар олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн хувилбарт үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай төсөв хөрөнгийг халамжийн нийгмийн ажилтан нь Амьжиргааг дэмжих зөвлөлд оруулан шийдвэрлүүлэхээр заасан. Ингэснээр тухайн гэр бүлийг ажилтай, орлоготой болгох, хүчирхийллийг өдөөгч хүчин зүйлс болох архидалт, ядуурлын асуудлыг шийдвэрлэнэ гэж үзвэл үйл ажиллагааг нь холбон зохион байгуулж болох юм. Энэхүү хуулиар халамж, хамгааллын үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчийг бусад шаардлагатай халамжийн үйлчилгээнд холбон зуучилж өөр байгууллага, мэргэжилтнээр тус үйлчилгээг үзүүлж болохыг заасан. Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь магадлан итгэмжлэгдсэн байна.

2.4 ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЗҮГЭЭС ГАРЧ БОЛОХ АСУУДАЛ, БЭРХШЭЭЛ, АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ

Хамтарсан багийн гишүүн халамжийн халамжийн нийгмийн ажилтан нь кейс менежментийн үйлчилгээг үзүүлэхэд дараах асуудал бэрхшээл тулгарч болно. Эдгээр асуудал нь хамгааллын үйлчилгээ үзүүлж буй ажилтны хувьд төдийгүй үйлчилгээ үзүүлж иргэнтэй харилцах явцад гарч болох түгээмэл асуудал гэдгийг санаарай.

- Ууртай, тогтворгүй зан араншинтай үйлчлүүлэгчтэй тулгарах,
- Ирээдүйд болон өөртөө итгэх итгэлгүй болсон үйлчлүүлэгчтэй ажиллах,
- Халамжийн үйлчилгээ хөтөлбөрт хамрагдах шаардлага хангахгүй ч тэтгэмж, тусламж авахыг хүссэн иргэний сөрөг хандлага,
- Архи болоод мансууруулах бодис хэрэглэдэг үйлчлүүлэгчтэй ажиллах,
- Буруутгагдах: төрөөс халамжийн үйлчилгээ авч чадахгүй байгаад халамжийн нийгмийн ажилтныг буруутгах,
- Гүтгүүлэх: Үйлчилгээ авч чадаагүйгээс, эсхүл хор хүргэх зорилготой үйлчлүүлэгчид гүтгүүлэх, сэтгэл зүйн дайралтад өртөх,
- Үйлчлүүлэгчийн үнэлгээг хийх зорилгоор гэрт нь, амьдарч буй орчинд нь очих үед бие махбодод хор хөнөөл учруулах гэх мэт.

Энэ бүх сөрөг хүчин зүйлс, гарч болох аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах гол арга барил нь хамтарсан багийн бусад гишүүдтэй хамтран ажиллан ажиллах явдал юм. Ингэснээр хамтарсан багаар үйлчилгээг хүргэснээр, өөрийгөө болон бусад гишүүдээ хамгаалж чадна.

Халамжийн нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгчтэйгээ харилцахдаа мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллана.

Хүснэгт 6. Үйлчлүүлэгчтэй харилцах, ярилцах, сонсох арга

Харилцах	Ярилцах	Сонсох
Үйлчлүүлэгч өөрт тулгарч буй асуудал, ямар үйлчилгээ хэрэгтэй байгааг тодорхойлоход нөлөөлөх гол зүйл нь харилцаа байдаг. Харилцааны 35% нь аман, 65% нь аман бус хэлбэртэй. Аман бус хэлбэр нь нүүрний хувирал, дуу хоолойны өнгө, хөдөлгөөн, дохио зангаа, гадаад байдал зэргийг багтаадаг. Үгээр илэрхийлж буй хэл яриа, биеэрээ илэрхийлж буй хөдөлгөөн, нүүр царайны хувирал, дууны өнгө, элдэв хөдөлгөөн зэрэг нь харилцаанд чухал нөлөөтэй.	Ярилцлагань ажилтан, үйлчлүүлэгч хоёр нүүр тулан уулзаж, хэрэгцээ, асуудлыг шийдвэрлэх зорилгоо бие биедээ мэдээлэл өгч буй хэлбэр. Уулзалтаар ажилтан болон үйлчлүүлэгч бие биеэ таньж мэдэх, ажилтан үйлчлүүлэгчийн хэрэгцээ, асуудлыг тодорхойлох, цаашид хамрагдах үйлчилгээний төрлийг тогтооход чухал нөлөөтэй. Ярилцлага нь нэг удаагийн эсвэл асуудлын цар хүрээнээс шалтгаалан давтан хэд хэдэн ч удаа явагдаж болно.	Сонсох чадвар гэдэг нь үйлчлүүлэгчийн хэлж байгаа үг, дуу хоолойн өнгө, үйл хөдөлгөөн, сэтгэл хөдлөл зэргээр илэрхийлж буй зүйлийг бүхэлд нь анхааралтай хүлээж авахыг хэлнэ. Хэрвээ аль нэгийг нь анзаараагүй бол үйлчлүүлэгчийн илэрхийлж буй хамгийн чухал мэдээллийг мэдэлгүй өнгөрөх магадлалтай.

Үйлчлүүлэгч нь халамжийн нийгмийн ажилтны өгсөн зөвлөгөөг бүрэн авахгүй байх, авах эсэх сонголтоо хийх нь тухайн үйлчлүүлэгчийн шийдэх хэрэг тул тулгахгүй, өөрөө өөрийнхөө төлөө шийдвэр гаргахад туслаарай. Мөн таны өгсөн зөвлөгөөг авахгүй бол битгий шантраарай. Учир нь тухайн хүний онцлог, нөхцөл байдлаас хамааран өөрчлөгдөх хугацаа хэрэгтэй байдаг.

Сайн зөвлөгчийн үндсэн ур чадвар нь сайн сонсогч байх явдал юм. Сайтар сонсож, асуудлыг уг үндсээр нь ойлгож, үйлчлүүлэгчээ зөв тайвшруулан, асуудалд бодитой хандсанаар шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлж чадна.

Хүснэгт 7. Халамжийн нийгмийн ажилтны зөвлөгөө өгөх ур чадвар

Зөвлөгчийн ур чадвар	Зөвлөгчийн анхаарах зүйлс
Хүнлэг байх Ялгаварлан гадуурхахгүй байх Сэтгэлээ хуваалцаж чаддаг Сайн сонсогч Нууцыг хадгалах Асуудалд дүн шинжилгээ хийх Тэвчээртэй байх	Зөвлөгөө өгөхдөө шийдвэр гаргах боломжийг үйлчлүүлэгчдээ үлдээх Ярилцлага хийх орчин, нөхцөл тохиромжтой байх Үйлчлүүлэгчийг буруутгахгүй байх Амлалт өгөхгүй байх Мэдрэмжтэй харилцах: Үйлчлүүлэгчийг "хэт онцгойлон" анхаарах нь эвгүй мэдрэмжийг төрүүлж мэднэ

Ялангуяа, халамжийн үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчдэд төрөөс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, хууль дүрэм журмын талаар энгийн ойлгомжтой ярьж, тайлбарлах шаардлага тулгарна.

Нөгөө талаар хүн ёсны хувьд хүнлэг харилцаж, дэмжиж, тулгараад байгаа асуудлаас гарах гарц, шийдэл боломжийг тайлбарлан зөвлөөрэй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <http://legalinfo.mn/law/details/12393>

Хүүхэд хамгааллын тухай хууль. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <http://www.legalinfo.mn/law/details/11710>

Нийгмийн халамжийн тухай хууль. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail/393>

ХНХЯ, СЯ (2022). "Аргачлал, зардлын норматив батлах тухай" тушаал

Э.Дуламсүрэн, Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, Хамгааллын алхмууд: Кейс менежментийн нийтлэг арга зүй, УБ.,2020

Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг стандарт, MNS 6949:2021

Б.Сүх-Очир, Халамжийн нийгмийн ажилтны гарын авлага, УБ.,2016, 2019

Г.Түмэннаст, Ажилд зуучлах магистрын хөтөлбөрийн стратеги ба хөдөлмөр эрхлэлтэд чиглэсэн кейс менежмент, Зайн сургалтын гарын авлага, УБ.,2018

[illegible]

[illegible]

